# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2018 оны 05 сарын 10 өдөр Дугаар 1/105/ГАГ-БНАТАГ-/2018/-01-ГА Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Номгон хүнс" ХХК нь "Тост" гоймонгийн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан боловч үйл ажиллагаа эхлүүлээгүй байна.

Дээрх нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам"-ын 7.1-т заасан "Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүжилтээ авснаас хойш хуанлийн 60 хоногийн дотор үйл ажиллагааг эхлүүлсэн байх ёстой", ХОЗГ-2017/08/01 тоот хөрөнгө оруулалтын зээлийн гэрээний 7.1.2-т заасан "Төслийн санхүүжилтийг зориулалт бусаар ашигласан тохиолдолд гэрээний үүргийг зөрчсөнд тооцно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар ашигласан 50.0 сая /тавин сая / төгрөгийг "Номгон хүнс" ХХК-аар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад төлбөр хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2518093

2. Төлбөрийн актаар тогтооосон 50.0 сая /тавин сая/ төгрөгийг барагдуулсан тухай баримтыг 2018.06.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа, "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.

**АКТ**

| **ТОГТООСОН[1]:** | **ЗӨВШӨӨРСӨН:** |
|---|---|
| АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА | СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА |
| АУДИТОР Б.АЗБАЯР | ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БАТЦЭРЭН |
| | АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Р.НАРАНЦЭЦЭГ |

*1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2018 оны 05 сарын 10 өдөр Дугаар 2/107/ТАГ- БНАТАГ- /2018/-01-ТА Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017.07.03-ны өдөр монгол тоглоом үйлдвэрлэх зорилгоор 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан "Нэм хонгор" ХХК 1,0 сая төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байна.

Дээрх нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ын 7.6-т заасан “Төслийн санхүүжилтийг эргэн төлөх хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх”, ХОЗГ-2017/07/01 тоот хөрөнгө оруулалтын зээлийн гэрээний 5.2.2-т заасан “төслийн санхүүжилтийн дэмжлэгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу эргэн төлөх төлбөрийг сарын 28-ны дотор ... дансанд тушаах”, 5.2.5-т заасан “Төслийн санхүүжилтийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх” зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

2518095

1. Эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн 1,000,000 /Нэг сая / төгрөгийг “Нэм хонгор” ХХК-аар төлүүлж, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн Хасбанк дахь 5002108778 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актаар тогтооосон 1,000,000 /Нэг сая/ төгрөгийг барагдуулсан тухай баримтыг 2018.06.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.

**АКТ**

| **ТОГТООСОН[1]:** | **ЗӨВШӨӨРСӨН:** |
|---|---|
| АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА | СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА |
| АУДИТОР Б.АЗБАЯР | ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БАТЦЭРЭН |
| | АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Р.НАРАНЦЭЦЭГ |

641743544
БЮА0067 9007423

*1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2018 оны 05 сарын 10 өдөр Дугаар 3/108/ТАГ- БНАТАГ-/2018/-01-АА Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017.06.23-ны өдөр эрчимжсэн мал аж ахуй, сувилал ажиллуулах зорилгоор 45,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан "Гурван цахир" хоршоо нь 2018 оны 1-4 дүгээр саруудад төлөх 6,0 сая төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байна.

Дээрх нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам"-ын 7.6-т заасан "Төслийн санхүүжилтийг эргэн төлөх хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх", ХОЗГ-2017/06/01 тоот хөрөнгө оруулалтын зээлийн гэрээний 5.2.2-т заасан "төслийн санхүүжилтийн дэмжлэгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу эргэн төлөх төлбөрийг сарын 28-ны дотор ... дансанд тушаах", 5.2.5-т заасан "Төслийн санхүүжилтийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

2518097

1. Эргэн төлөгдөөгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийн 6,000,000 /Зургаан сая / төгрөгийг “Гурван цахир” хоршоогоор төлүүлж, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн Хасбанк дахь 5002108778 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актаар тогтооосон 6,000,000 /Зургаан сая/ төгрөгийг барагдуулсан тухай баримтыг 2018.06.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.

**АКТ**

| **ТОГТООСОН**[1]**:** | | **ЗӨВШӨӨРСӨН:** | |
|---|---|---|---|
| АХЛАХ АУДИТОР | Б.ДОЛЖМАА | СТСХ-ИЙН ДАРГА | С.БАЙГАЛМАА |
| АУДИТОР | Б.АЗБАЯР | ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | С.БАТЦЭРЭН |
| | | АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН | Р.НАРАНЦЭЦЭГ |

641714354Ч
БЮА0067 9007423

*1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*